



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2026 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/06

Дадал сум

Байгууллагын дотоод хяналт шалгалт
зохион байгуулах ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11 Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын “Дотоод хяналт шалгалт”-ыг зохион байгуулах ажлын хэсгийг дор дурьдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хэсгийн ахлагч:	О.Урансайхан (Аргазүйч)
Гишүүд:	Б.Амаржаргал (Багшийн туслах)
	О.Алтанцэцэг (Ахлах тогооч)
	С.Батцэцэг (Угаагч)
	Х.Отгонжаргал (Жижүүр)

2. Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ыг багш ажилтан бүрийн хүлээсэн үүргийн хэрэгжилт, хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлт, өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, шилэн дансны хэрэгжилт зэргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тусган боловсруулж батлуулан мөрдөж ажиллахыг ажлын хэсэг бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/10 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЭРХЛЭГЧ Н.ОДГАРАВ

